

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт-Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2024/05/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Аудитор: Б.Бямбатогтох
Утас: 70357955 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.03.14 № 74

танай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭТ УС, ДУЛААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ОНӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БҮҮВЭЙБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 119/ШШ2023/0001 дугаартай Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр 199.9 сая төгрөгийн нөхөн ногдуулалтын актын үлдэгдэл төлбөр болох 186.4 сая төгрөгийг Булган аймгийн Татварын хэлтсийн нэхэмжлэхээр шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 06 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 26,256.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 26,715.7 сая төгрөгөөр, 459.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,805.2 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 28,004.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 28,041.8 сая төгрөгийн зардал гарган, 37.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, алдагдлыг төлөвлөснөөс 421.6 сая төгрөгөөр бууруулж ажиллажээ.

D:\my doc\alban bichig\2024-A4.doc

Тайлант онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 3,175,162.3 м³ ус хүлээн авч, 2,137,427.6 м³ ус буюу 67.32 хувийг борлуулж, 32.68 хувь буюу 1,037,734.8 м³ усыг орлого болоогүй усны өглөгөөр бүртгэж тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ний 2023 оны гүйцэлгэлийн төлөвлөгөөнд 15 зорилт, 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлийг дээд шатны захирагч 98.05 хувьтай гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэгэн төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2023.01.01	2023.12.31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,522,130,487.00	4,101,383,982.66
1.1.02	Дансны авлага	13,867,621,225.01	15,202,440,466.72
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	32,262,916.06	9,251,712.44
1.1.04	Бусад авлага	6,919,812.13	8,766,251.58
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	2,870,365,528.40	3,156,447,204.66
1.1.06	Бараа материал	1,161,377,247.50	1,084,217,524.63
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	20,460,677,216.10	23,562,507,142.69
1.2.01	Үндсэн хөрөнгө	52,312,235,646.22	56,611,725,238.17
1.2.02	Биет бус хөрөнгө	123,530,164.62	126,145,640.10
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	6,364,370,472.34	7,082,891,795.12
1.2.09	Газар / Биет бус хөрөнгө - Бусад /	2,480,362,800.00	2,480,362,800.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	61,280,499,083.18	66,301,125,473.39
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	81,741,176,299.28	89,863,632,616.08
2.1.1.01	Дансны өглөг	13,678,270,311.07	14,821,052,001.61
2.1.1.03	Татварын өр	0.00	16,125,959.54
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	764,562,619.84	967,043,853.20
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	49,855,316.24	44,420,046.79
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	14,492,688,247.15	15,848,641,861.14
2.1.2.05	Хойшлогдсон орлого	6,364,370,472.34	7,082,891,795.12
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,364,370,472.34	7,082,891,795.12
2.2	Өр төлбөрийн нийт дүн	20,857,058,719.49	22,931,533,656.26
2.3.01	Өмч: - төрийн	5,231,568,753.18	5,231,568,753.18
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,586,709,828.68	2,553,427,873.78
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	58,732,662,273.79	64,818,312,139.37
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-5,666,823,275.86	-5,671,209,806.51
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-37,668,485.55
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-5,666,823,275.86	-5,633,541,320.96
2.3.11	Эздийн өмчийн дүн	60,884,117,579.79	66,932,098,959.82
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	81,741,176,299.28	89,863,632,616.08

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	23,920,693,900.00	27,213,278,870.19
02	Борлуулалтын өртөг	14,819,055,787.28	15,324,052,466.04
03	Нийт ашиг(алдагдал)	9,101,638,112.72	11,889,226,404.15
08	Бусад орлого	214,648,200.00	230,653,408.03
08.1	Орлогын дүн	214,648,200.00	230,653,408.03
10	Ерөнхий ба удирдлагын зардал	10,014,633,723.64	12,674,607,370.83
12.1	Зардлын дүн	10,014,633,723.64	12,674,607,370.83
17	Бусад ашиг (алдагдал)	393,935,082.89	521,312,012.05
17.1	Олз, гарзын дүн	393,935,082.89	521,312,012.05

18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-304,412,328.03	-33,415,546.60
19	Орлогын татварын зардал	0.00	4,252,938.95
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-304,412,328.03	-37,668,485.55
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-304,412,328.03	-37,668,485.55

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,231,568,753.18	2,586,709,828.68	43,302,195,875.79	-	45,758,063,509.82
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-304,412,328.03	-304,412,328.03
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	15,430,466,398.00	0.00	15,430,466,398.00
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,231,568,753.18	2,586,709,828.68	58,732,662,273.79	-	60,884,117,579.79
11	Залруулсан үлдэгдэл	0.00	-33,281,954.90	0.00	33,281,954.90	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-37,668,485.55	-37,668,485.55
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	6,085,649,865.58	0.00	6,085,649,865.58
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	5,231,568,753.18	2,553,427,873.78	64,818,312,139.37	-	66,932,098,959.82

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	28,660,671,686.62	31,110,916,461.49
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	27,760,353,962.45	28,777,664,670.26
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	300,000,000.00	300,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	600,317,724.17	2,033,251,791.23
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	26,770,093,427.61	29,139,548,185.83
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,102,227,313.01	4,772,699,137.99
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,235,221,060.00	801,417,860.99
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,640,361,921.70	2,533,978,422.11
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	472,657,970.48	672,193,086.34
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	255,780,885.00	214,652,852.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,797,141,489.24	1,836,894,972.00

1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	5,150,870.00	3,101,670.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	17,261,551,918.18	18,304,610,184.40
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,890,578,259.01	1,971,368,275.66
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	428,104,696.10	392,114,780.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	428,104,696.10	392,114,780.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-428,104,696.10	-392,114,780.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,462,473,562.91	1,579,253,495.66
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,059,656,924.09	2,522,130,487.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,522,130,487.00	4,101,383,982.66

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт (хувиар)
1. Ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн буюу техникийн үзүүлэлт							
1.1	Цахилгаан эрчим хүчээр хангах хэрэглэгчид	Айл өрх	9498	9498	10087	(589)	106.2
		ААНБ	812	812	839	(27)	103.3
1.2	Дулаанаар хангах хэрэглэгчид	Айл өрх	14382	14382	14947	(565)	103.9
		ААНБ	1325	1325	1325	0	100.0
1.3	Цэвэр усаархангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ үзүүлэх хэрэглэгчид	Айл өрх	14321	14361	15109	(748)	105.2
		ААНБ	1474	1474	1333	141	90.4
1.4	Ус түгээх байр	ширхэг	93	93	94	(1)	101.1
1.5	Ажиллагсад	хүн	314	326	314	12	96.3
1.6	Дундаж цалин	Мян.төг	1,273,614.0	1,473,725.5	1,499,870.0	(26,144.47)	101.8
2. Орлого, зардал, ашгийн буюу эдийн засгийн үзүүлэлт							
2.1	Нийт орлого	Мян.төг	24,591,524.0	26,256,484.1	28,004,174.4	(1,747,690.3)	106.7
2.1.1	Цахилгаан	Мян.төг	7,083,528.3	8,083,487.4	8,788,815.0	(705,327.6)	108.7
2.1.2	Дулаан	Мян.төг	8,335,449.9	8,855,563.0	9,480,240.1	(624,677.1)	107.1
2.1.3	Цэвэр ус хангамж	Мян.төг	4,475,697.8	4,771,993.7	4,611,178.4	160,815.3	96.6
2.1.4	Ариутгах татуурга	Мян.төг	3,297,920.4	3,421,507.6	3,320,805.6	100,702.0	97.1
2.1.5	Цахилгаан шат	Мян.төг	174,712.0	176,951.0	180,378.2	(3,427.2)	101.9
2.1.6	ӨЭУУ хангамж	Мян.төг	946,801.9	895,377.6	924,091.2	(28,713.6)	103.2
2.1.7	Тоолуурын хэсэг	Мян.төг	62,765.5	51,603.8	86,213.8	(34,610.0)	167.1
2.1.8	Бусад	Мян.төг	214,648.2		612,452.1	(612,452.1)	

2.2	Нийт зардал	Мян.төг	24,895,936.3	26,715,736.0	28,041,842.9	(1,326,106.9)	105.0
2.2.1	Үндсэн ба нэмэгдэл цалин	Мян.төг	4,798,978.1	5,765,213.8	5,651,510.2	113,703.6	98.0
2.2.2	Ажил олгогчоос төлөх НДШ	Мян.төг	651,867.4	782,265.0	771,174.4	11,090.6	98.6
2.2.3	Цахилгаан	Мян.төг	814,477.1	985,956.7	1,043,262.1	(57,305.4)	105.8
2.2.4	Дулаан	Мян.төг	20,036.6	27,684.9	25,581.8	2,103.1	92.4
2.2.5	Ус	Мян.төг	44,976.6	29,568.6	50,515.1	(20,946.5)	170.8
2.2.6	Урсгал засвар, сэлбэг	Мян.төг	452,863.8	474,195.1	567,916.0	(93,720.9)	119.8
2.2.7	Түлш шатахуун	Мян.төг	186,019.9	258,059.4	165,091.2	92,968.2	64.0
2.2.8	Албан томилолт	Мян.төг	4,480.3	11,636.0	17,895.6	(6,259.6)	153.8
2.2.9	Бичиг хэрэг	Мян.төг	29,674.9	41,032.0	30,906.1	10,125.9	75.3
2.2.10	Холбоо	Мян.төг	27,820.3	26,601.5	28,501.2	(1,899.7)	107.1
2.2.11	Хөдөлмөр хамгаалал	Мян.төг	181,788.2	280,063.5	252,969.4	27,094.1	90.3
2.2.12	Элэгдэл	Мян.төг	2,374,178.1	2,867,035.3	2,901,598.5	(34,563.2)	101.2
2.2.13	Зар сурталчилгаа	Мян.төг	10,887.1	14,000.0	3,272.7	10,727.3	23.4
2.2.14	Нийгмийн халамж	Мян.төг	199,916.0	300,029.4	238,941.7	61,087.7	79.6
2.2.15	ТЗЭ-ийн зохицуулалтийн хөлс	Мян.төг	47,173.6	45,630.0	45,341.3	288.7	99.4
2.2.16	Татвар, даатгалын зардал	Мян.төг	29,661.8	32,010.9	169,148.9	(137,138.0)	528.4
2.2.17	Гаднын үйлчилгээний хөлс	Мян.төг	40,394.3	60,484.5	36,641.9	23,842.6	60.6
2.2.18	Бусад үндсэн үйл ажиллагаа	Мян.төг	99,439.6	189,306.9	678,592.1	(489,285.2)	358.5
2.2.19	Худалдан авсан эрчим хүч	Мян.төг	14,819,055.8	14,503,171.3	15,324,052.5	(820,881.2)	105.7
2.2.20	Үйл ажиллагааны бус зардал	Мян.төг	62,246.8	21,791.2	38,930.2	(17,139.0)	178.7
2.2.21	Орлого болоогүй усны төлбөр	Мян.төг	-			-	
2.3	Ашиг, алдагдал	Мян.төг	(304,412.3)	(459,251.9)	(37,668.5)	(421,583.4)	8.2

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 204.3 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 202.5 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд анхан шатны баримтгүй 1.7 сая төгрөгийн ажил гүйлгээг кассаар зарцуулсан, байгууллагын захирал ТУЗ-өөр батлуулаагүй, хот суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооноос гаргасан шалгаруулалтын дүнг үндэслэн өөртөө 0.07 сая төгрөгийн урамшуулал авсан зэрэг зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Цалингийн хэмнэлтээс албан хаагчдад урамшуулал олгосон, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн "Эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг шинэчилж, тооллогын комисс эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлээр хөрөнгийг тулгаж тоолж байх" гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Албан томилолтын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Албан томилолтын анхан шатны 0.7 сая төгрөгийн баримт нөхөн бүрдүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийхгүй байх.

2. Эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бизнес төлөвлөгөөнд тусгасан зардлын төлөвлөгөөнөөс цахилгааны зардлыг 57.3 сая төгрөгөөр, усны хэрэглээний зардлыг 20.9 сая төгрөгөөр, урсгал засвар, сэлбэгийн зардлыг 93.7 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 6.3 сая төгрөгөөр, холбооны зардлыг 1.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 3.1-д "Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмнөх оны гүйцэтгэл, бусад тооцоо судалгаанд үндэслэн төсвийг бодитой төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж байх.

3. Эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй, цалингийн хэмнэлтээс албан хаагчдад 21.6 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 3.1-д "Энэ хууль нь

төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна". 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан урамшууллыг албан хаагчдад олгож байх.

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын ТАХ-ний төлөвлөгөө, зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг бүрэн байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК	6	204.3	2	1.8	1	-	3	202.5				
Дүн	6	204.3	2	1.8	1	-	3	202.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК	1	-					1	-
Дүн	1	-					1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨХК	1	1			1			
	НИЙТ	1	1			1			